



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн 13 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2025/70/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.open.audit.mn

Архангай аймаг

2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerquibaatar@audit.gov.mn

Аудитор С.Оргил

Утас: 77665858

Цахим хаяг: Shinjenmagadlahui.ezsh.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.02.24 № 56

танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН
СУМЫН ХҮҮХДИЙН 13 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Ё.МАНДУХАЙ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн 13-р цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн хүрээнд нийт 10 арга хэмжээнд төсвөөс 671,152.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэл 89.2 хувь буюу 598,745.3 мянган төгрөгийг зарцуулж, 64,823.9 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн 13-р цэцэрлэг нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 үндсэн зорилтын хүрээнд 123 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 92.0 хувьтай байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	122,376,922.73	130,844,499.88
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	72,731,385.00	64,823,902.15
312	Банканд байгаа бэлэн мөнгө	72,731,385.00	64,823,902.15
3121	Төгрөг	72,731,385.00	64,823,902.15
31211	Төрийн сангийн харилцах	72,731,385.00	64,823,902.15
35	БАРАА МАТЕРИАЛ	49,645,537.73	66,020,597.73
354	Хангамжийн материал	49,645,537.73	66,020,597.73
3542	Аж ахуйн материал	49,945,537.73	66,020,597.73
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	816,332,181.09	968,658,358.27
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	816,332,181.09	968,658,358.27
392	Биет хөрөнгө	813,835,681.09	966,439,358.27
39201	Барилга, байгууламж, орон сууц	861,230,096.00	1,015,411,256.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-71,769,174.60	-86,123,009.52
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	38,957,986.00	58,099,872.00
2539206	Хуримтлагдсан элэгдэл	-20,163,490.83	-25,200,404.77
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,286,201.40	13,286,201.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,705,936.88	-9,034,556.84
393	Биет бус хөрөнгө	2,496,500.0	2,219,000.0
39301	Программ хангамж	1,537,500.00	1,537,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,185,000.00	-1,462,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	2,144,000.00	2,144,000.0
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	938,709,103.82	1,099,502,858.15
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	938,709,103.82	1,099,502,858.15
51	Засгийн газрын хувь оролцоо	2,144,000.00	2,144,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	708,112,785.42	868,906,539.75
5121	Өмнөх үеийн үр дүн	708,112,785.42	708,112,785.42
5122	Тайлант үеийн үр дүн		160,793,754.33
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	228,452,318.40	228,452,318.40
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	938,709,103.82	1,099,502,858.15

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	472,495,000.00	778,135,310.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,602,000.00	179,854,310.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,602,000.00	179,854,310.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	175,000.00	140,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	175,000.00	140,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	6,427,000.00	174,202,560.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Бараа материал		5,511,750.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	465,893,000.00	598,281,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	427,522,900.00	552,956,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	427,522,900.00	552,956,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	38,370,100.00	45,325,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38,370,100.00	45,325,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	453,05,2788.91	617,341,555.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	453,052,788.91	617,341,555.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	452,466,176.84	609,758,436.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	299,843,010	440,312,833.00
210101	Үндсэн цалин	232,609,036.00	323,920,413.00
210102	Нэмэгдэл	57,365,235.00	100,243,470.00
210104	Урамшуулал	9,868,739.00	16,148,950.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,394,094.00	55,742,712.85
210201	Тэтгэврийн даатгал	26,403,604.58	38,744,851.39
210202	Тэтгэмжийн даатгал	3,163,628.87	4,449,322.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,442,903.09	2,218,061.42
210204	Ажилгүйдлийн даатгал	606,358.25	2,066,125.47
210205	Эрүүл мэндийн даатгал	5,777,599.21	8,264,352.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,283,487.93	30,241,881.00
210301	Гэрэл, цахилгаан	6,188,881.93	6,124,801.00
210302	Түлш, халаалт	20,232,000.00	20,232,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,862,606.00	3,885,080.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,879,284.88	
210401	Бичиг хэрэг	4,879,284.88	
2105	Нормативт зардал	38,893,441.00	44,182,537.00
210502	Хоол, хүнс	38,893,441.00	44,182,537.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,825,290.00	2,060,189.00
210604	Урсгал засвар	5,825,290.00	2,060,189.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	796,700.00	496,900.00
9210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	796,700.00	496,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,550,869.03	36,721,383.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,355,690.00	8,231,024.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,199,540.00	3,713,977.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	24,995,639.03	24,776,382.82
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	586,612.07	7,583,119.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		7,583,119.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		7,583,119.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)		
767V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	466,068,000.00	598,421,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	175,000.00	140,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	175,000.00	140,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	175,000.00	140,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	175,000.00	140,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	465,893,000.00	598,281,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	427,522,900.00	552,956,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	427,522,900.00	552,956,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	38,370,100.00	45,325,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38,370,100.00	45,325,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	428,026,745.00	603,428,482.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	428,026,745.00	603,428,482.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	427,440,132.93	595,845,363.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	299,843,010.00	440,312,883.00
210101	Үндсэн цалин	226,472,508.00	321,431,563.00
210102	Нэмэгдэл	63,582,692.00	102,779,872.00
210104	Урамшуулал	9,787,810.00	16,101,448.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,394,094.00	55,742,662.85
210201	Тэтгэврийн даатгал	26,559,755.37	38,709,511.14
210202	Тэтгэмжийн даатгал	3,117,442.54	4,458,105.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,394,587.61	2,222,453.17
210204	Ажилгүйдлийн даатгал	574,781.08	2,2070,517.22
210205	Эрүүл мэндийн даатгал	5,747,527.40	8,282,075.77
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,283,487.93	30,241,881.00
210301	Гэрэл, цахилгаан	6,188,881.93	6,124,801.00
210302	Түлш, халаалт	20,232,000.00	20,232,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,862,606.00	3,885,080.00
2105	Нормативт зардал	38,893,441.00	44,182,537.00
210502	Хоол, хүнс	38,893,441.00	44,182,537.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,500,000.00	4,600,000.00
210604	Урсгал засвар	7,500,000.00	4,600,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	796,700.00	1,824,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	796,400.00	1,824,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,729,400.00	18,941,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,339,300.00	13,382,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,390,100.00	5,558,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	586,612.07	7,583,119.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		7,583,119.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	586,612.07	7,583,119.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	38,041,255.00	-5,007,482.85
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		2,900,000.00
	Дотоод эх үүсвэрээр		2,900,000.00

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 13 дугаар цэцэрлэгийн 2024 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		2,900,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		-2,900,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	38,041,255.00	-7,907,482.85
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		- 72,731,385.00
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		- 64,823,902.15

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			708,112,785.42	938,709,103.82
9	Тайлант үеийн үр дүн	-	-	160,793,754.33	160,793,754.33
10	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл			868,906,539.75	1,099,502,858.15

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	671,152,200.00	598,745,363.85	-72,406,836.15	89.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	671,152,200.00	598,745,363.85	72,406,836.15	89.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	671,152,200.00	598,745,363.85	72,406,836.15	89.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	492,706,500.00	440,312,883.00	52,393,617.00	88.02
210101	Үндсэн цалин	364,442,500.00	321,431,563.00	43,010,937.00	88.20
210102	Нэмэгдэл	124,868,400.00	102,779,872.00	22,088,528.00	82.31
210104	Урамшуулал	3,395,600.00	16,101,448.00	-12,705,848.00	74.37
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,041,400.00	55,742,662.85	2,298,737.15	96.04
210201	Тэтгэврийн даатгал	39,469,100.00	38,709,511.14	759,588.86	98.08
210202	Тэтгэмжийн даатгал	4,642,400.00	4,458,105.55	184,294.45	96.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,321,600.00	2,222,453.17	99,146.83	95.73
210204	Ажилгүйдлийн даатгал	2,321,600.00	2,070,517.22	251,082.78	89.18
210205	Эрүүл мэндийн даатгал	9,286,700.00	8,282,075.77	1,004,624.23	89.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,825,000.00	30,241,881.00	7,583,119.00	79.95
210301	Гэрэл, цахилгаан	7,199,500.00	6,124,801.00	1,074,699.00	85.07
210302	Түлш, халаалт	20,232,000.00	20,232,000.00		100.00
210303	Цэвэр, бохир ус	10,393,500.00	3,885,080.00	6,508,420.00	37.38
2105	Нормативт зардал	52,987,300.00	44,182,537.00	8,804,763.00	83.38
210502	Хоол, хүнс	52,987,300.00	44,182,537.00	8,804,763.00	83.38
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,500,000.00	7,500,000.00		100.00
210604	Урсгал засвар	7,500,000.00	7,500,000.00		100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,824,300.00	1,824,300.00		100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,824,300.00	1,824,300.00		100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,127,700.00	18,941,100.00	1,186,600.00	94.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,569,200.00	13,382,600.00	1,186,600.00	80.53
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,558,500.00	5,558,500.00		100
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ				
	Дотоод эх үүсвэрээр				
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	671,152,200.00	590,837,881.00	80,314,319.600	88.65

131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	552,956,000.00	552,956,000.00	0.00	100
131001	Улсын төсвөөс санхүүжих	552,956,000.00	552,956,000.00	0.00	100
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	45,325,000.00	37,741,881.00	7,583,119.00	83.27
132001	Орон нутгийн төсвөөс	45,325,000.00	37,741,881.00	7,583,119.00	83.27
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	72,871,200.00	140,000.00	72,731,200.00	0.19
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140,000.00	140,000.00		
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	72,731,200.00		72,731,200.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		72,731,385.00	-72,731,385.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		64,823,902.15	-64,823,902.15	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО		1		100
610001	Төсвийн байгууллага		1		100
5	АЖИЛЛАГСДЫН ТОО		22		100
6	Удирдах ажилтан		2		100
7	Гүйцэтгэх ажилтан		4		100
8	Үйлчлэх ажилтан		16		100

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа залруулаагүй байна. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 2 зөрчил¹ илэрсэн бөгөөд зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүллээ. Аудитаар илэрсэн зөрчил нь материаллаг бус байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

3.1. Зөвлөмж

3.1.1 Программ, бараа материалтай холбоотой

Илрүүлэлт: 1. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслийг Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн А/273 дугаар тушаалын хавсралтаар баталсан жагсаалтын дагуу эцэг, эх, асран хамгаалагчдаас хүлээн авсныг нягтлан бодох бүртгэл, тайланд тусгаагүй.

2. Нягтлан бодох бүртгэлийн цахим программыг өдөр тутмын ажил гүйлгээнд ашиглаагүй, бараа материалын зарлагын гүйлгээнүүдийг нэгтгэж сарын сүүлийн өдөр программд оруулсан, анхан шатны баримтыг программаар боловсруулаагүй гар аргаар хөтөлсөн байна.

Энэ нь Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4 дэх хэсэг, Төсвийн

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4, 16 дугаар зүйлийн 16.5.7 дахь заалттай нийцэхгүй байна.

Зөвлөмж: Аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх, цаашид нягтлан бодох бүртгэлийн программд бараа материалын гүйлгээг тухай бүртгэх, анхан шатны баримтыг программаар боловсруулах, хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслийг хүлээн авсан үед бараа материалын зохих дансанд орлогоор, сургалтын үйл ажиллагаанд тавьж олгосон тухай бүр зардлаар бүртгэж бараа материалын тайлан бэлтгэж үр дүнг санхүүгийн тайланд тусгаж, мэдээлэх арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг хүргүүлж байна.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "... албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасан тул зөвлөмжийн төлөвлөгөөг 2025.03.25-ны өдрийн дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлж ажиллана уу.

Энэхүү зөвлөмжийн төлөвлөгөөг ирүүлээгүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэгт заасан ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болохыг анхааруулна уу.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Програмтай холбоотой	1						1					
Бараа материалтай холбоотой	1						1					
Дүн	2						2					